



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 22 өдөр

Дугаар А/207

Мөрөн сум

Ахмадын асрамжийн байнгын  
үйлчилгээнд хамруулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Нийгмийн халамжийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн, 19.2.2, 19.4, Ахмад настны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.7, 7.2.7 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын иргэн Чогсомжав овогтой Ичинхорлоо (РП54072604) нь ах дүү нь харж хандах боломжгүй, өөрийн гэсэн орон гэргүй, байнгын асаргаанд байх шаардлагатай, ганц бие ахмад настан тул Ахмад настны асрамж үйлчилгээний төвд 2022 оны 06 дугаар сарын 06-ны өдрөөс байнгын асрамжийн үйлчилгээнд хамруулахыг аймгийн Ахмад настны асрамж үйлчилгээний төвийн дарга (Т.Октябрьбаяр)-д даалгасугай.

2. Тухайн иргэнийг аймгийн Ахмад настны асрамж үйлчилгээний төвд хүргэж өгөх ажлыг зохион байгуулахыг сумын Засаг дарга С.Гончигням-д үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс (Ч.Ганбаатар)-т даалгасугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН